



Б.НАРМАНДАХ
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх ерөнхий
газрын харьяа
СМДӨАЭАХХГ-ын
сэтгэл зүйч, дэслэгч

АРХИНЫ АЛБАДАН ЭМЧИЛГЭЭНД ЭМЧЛҮҮЛЭГДСДИЙН ОЮУН УХААН БОЛОН ХУВИЙН ОНЦЛОГИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТЭЭС

Манай улсын оршин тогтнох, хөгжин дэвших эх сурвалж нь Монгол хүн түүний тасралтгүй хөгжил, оюун ухааны чадавхи шинийг санаачилж ихийг бүтээх үйл явц юм. Гэтэл сүүлийн үед архинд донтох явдал нэмэгдсээр байгаа нь анагаах ухааны болон нийгмийн шинжлэх ухааны тулгамдсан асуудал болж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ архидан согтуурсны улмаас хордох, архинд донтох өвчтэй болохоос гадна зүрхний титэм судасны өвчин, тархинд цус харвах, чихрийн шижин зэрэг 60 гаруй өвчин архидалттай ямар нэг хэмжээгээр холбоотой үүсч даамжирч байгаагийн дотор элэгний хатуурал, улаан хоолой, элэгний хавдар, эпилепси болон осол гэмтэл, санаатайгаар хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа тохиолдлын 20-30 хувь нь архидалтаас үүдэлтэй байна гэж тооцоолжээ².

Нийт хүн амын 13.6% архинд донтох эмгэгтэй байгаа нь 1997 оны үзүүлэлтээс 16.4% /2 дахин ихэссэн байна. Жилд гарч байгаа гэмт хэргийн 68.2%-ийг согтуу хүн үйлдэж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 5 гэмт хэрэг тутмын нэг нь архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн байна. Гэр бүлийн тогтворгүй байдал, сөргөлдөөний гол шалтгааны 87%, гэр бүл салалтын шалтгааны 58.3% -ийг архидалт эзэлж байна. Оюуны хомсдолтой хүүхдүүдийн эцэг эхийн 58.4% нь архи хэтрүүлэн хэрэглэгчид байна. Нэг

жилдархинаас болж 1000 гаруй хүн хорвоог орхиж байна. Элэг, хоол боловсруулах эрхтний хорт хавдрын шалтгаанаар нас барагсдын 27.5% нь архи, согтууруулах ундаа байнга хэрэглэж байсан хүмүүс байна.

1989 онд батлагдаж 1992 оны 1-р сараас дэлхий даяар мөрдөгдөж байгаа өвчний олон улсын Х ангилалд "Архинд донтох өвчин-F10" хэмээн 10-р үйлд оруулсан ба архийг удаан хугацаанд хэтрүүлэн хортойгоор хэрэглэхэд бие сэтгэл уг ундаанд дасч, түүнийг байнга хэрэглэхийг шаардсан эмгэгийг архинд донтох өвчин гэж тодорхойлжээ. /Л. Эрдэнэбаяр, 1997/.

Архины тодорхойлолт: Америкийн Донтолтын Анагаах Нийгэмлэгийн тодорхойлсноор 6 бүрэлдэхүүн хэсэгтэй.

1. Архидалт бол өвчин бөгөөд
2. Энэ нь үргэлжлэх буюу давтагддаг байдлаар тодорхойлогдож,
3. Уух явдалдаа хяналт тавих чадваргүй болж,
4. Архи олох талаар үргэлж бодож,
5. Таатай биш үр дагавар.
6. Үгүйсгэлээр хамгийн ил тод илрэх гажуудсан бодол, сэтгэлгээг үл харгалзан уух явдал юм.

Согтууруулах ундааны төрөл

- Архи /спирт/ бол үнэн хэрэгтээ сэтгэцийн дарангуйлагч бодис юм. Спирт нь хүний мэдрэлийг сэргээгч аминдэм болох С,В-н бүлгийн амин дэмийг шатааж устгадаг учраас уураг тархинд С,В-н дутагдал бий болно. Спирт бол зөвхөн өвдөлтийг намдаах, түр зуур судас өргөсгөх, мансууруулах үйлчилгээ бүхий хоосон "илчлэг" гэж хэлж болно.
- Шар айраг /пиво/ архины дараа орох согтоох ундааны төрөл бол шар айраг юм. Шар айраг 5%-ийн нүүрс ус, 2.8%-6%-ийн спирт, МГ,СА-г тус бүр 9% мг, фосфор 12% мг, аминдэмийг маш бага хэмжээгээр агуулдаг, амархан шингэдэг



өргөн тархсан согтууруулах ундааны нэг юм. Шар айргийг ихээр уухад хэрэгцээгүй илчлэг болон шингэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр алкоголийн хортой үйлчилгээтэй хавсарч зүрх судасны систем болон бөөрөнд хэт ачаалал үүсгэдэг. Шар айраг нь эстрогенийг агуулдаг тул эрэгтэйчүүдийн бэлэг эрхтний тогтолцоонд таагүй нөлөө үзүүлдэг.

- Дарс /вино/ дарсны ихэнх төрөл нь 9%-20% спирт агуулдаг. Дарсыг дотор нь хуурай 9%-14% спирт агуулдаг, хатуулаг их 13%-20% спирт агуулдаг гэж хуваадаг.
- *Айраг согтууруулах ундаа мөн үү?* Гүүний сааманд айрагны хөрөнгө нэмж бүлж исгэх явцад айрганд этилийн спирт үүсдэг. Нутаг, нутгийн мөн тухайн айлын айрагны бүлэлт исэлдэлтээс хамаарч этилийн спиртийн агууламж нь 5- 18 градус хүртэл ялгаатай байдаг байна. Айраг нь шар айрагтай дүйцэхүйц согтоох чанартайбайдаг. Намрын айраг бүр илүү согтоох чанартай буюу спирт илүү агуулна. Иймд жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд айраг уухгүй байх нь зүйтэй гэж зөвлөж байна. Айрагны хувьд маргаантай мэт боловч одоогоор манайд бүрэн судалгаа байхгүй учраас нотолгоо хангалтгүй байж болох юм. Гэхдээ “нийгэмд архины хэрэглээний түвшин өндөр байна” гэж яригдаж байгаа нь бид бага наснаасаа айраг ууж өссөн мөн цаашид архи согтууруулах ундааг уусан тохиолдолд хэтрүүлэн хэрэглэх, архинд донтох өвчтэй болох суурийг тавьж өгдөг ч байж болно гэж зарим мэргэжилтнүүд үздэг байна.

Архийг хэтрүүлэн хэрэглэвэл таны бие махбодь болон сэтгэцэд сөрөг нөлөө үзүүлнэ.

- *Архины үйлчлэл* --- Уусан архины 20% ходоод, 80% нь нарийн гэдэсний ханаар шимэгдэж цусанд орж цусны урсгалаар элгэнд очно. Хүний элэг нэг цагт арван грамм архийг бүрэн гүйцэт задлах чадвартай.

- *Архи хүний биед:* Тархи --- Сэтгэн бодох, сй тогтоолт буурах, шинэ зүйл сурах чадвар багасах, зантөрхийн өөрчлөлт, хий үзэгдэл илрэх,сэтгэлээр унах, мэдрэлийн ядаргаа, хөдөлгөөний тэнцвэр, шийдвэр гаргах чадвар алдагдах
- *Элэг* --- Үйл ажиллагаа алдагдах,үрэвсэх, хатуурах, хавдар үүсэх,өвдөлт илрэх, элэг өөхлөх, архи даах чадвар муудах
- *Зүрх* --- Даралт ихсэх, зүрхний цохилт тогтворгүй болох,зүрхний булчин сулрах, цус багадах
- *Ходоод*--- Үрэвсэх, цус алдах, шархлаа үүсэх хоолны шингэц муудах, огиудас хүргэн цусаар бага хэмжээгээр бөөлжүүлж болзошгүй.
- *Нойр булчирхай* --- Үрэвсэх, өвдөлт ихтэй болох, инсулин багассанаас диабет үүсэх
- *Яс булчин* --- Булчин сулрах, яс сийрэгжих, булчингаар хүчтэй өвдөн хавдах
- *Уушиг* --- Ханиад, уушигны хатгалгаагаар өвчлөх
- *Мэдрэлийн систем* : Мэдрэлийн ширхгүүд үрэвсэж гэмтэх, нойргүйдэх, мэдрэлийн судал дагаж өвдөх, хөл чичрэх, мэдээгүй болох, тэнцвэр алдагдах, гар хуруу салганан чичрэх, бадайрах, богино хугацааны ой санамжаа алдах, хэл яриа ойлгомжгүй болох.
- *Бусад* --- Эрт хөгшрөх, хамар улайх, шарх сорви, арьс салст шарлах, бие загатнах, үс унах, ам залгиур хоолойн хорт хавдар, хөхний хорт хавдар, ходоодны хавдар
- *Эрэгтэйчүүд* --- Бэлгийн чадавхи буурах
- *Эмэгтэйчүүд* --- Бага жинтэй хүүхэд төрөх, ургийн гажиг үүсэх,хүүхдийн өсөлт хөгжилт удаашрах
- *Ерөнхий оорчлолтүүд* --- Бухимдаж ажлын чадвар алдагдах, янз бүрийн гэмтэлд өртөх, турах, зан үйл авирт өөрчлөлт гарах, бэлгийн сулралд орох, цусны бүлэгнэлт буурах,бие хүний



доройтолд орох, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг сөрөг шр дагаврыг дагуулдаг.

Архины хэрэглээгээр нь бүх хүмүүсийг 5 бүлэгт хувааж үзэж болно. Үүнийг пирамид хэлбэрээр дүрслэн харуулсан байдаг.

Архины хэрэглээний түвшин буюу Скиннерийн пирамид:



Пирамидындоод сууринаас орой руу явах тусам архины хэрэглээ, хэмжээ, эрсдэлт байдлууд ихэснэ. Оройд нь архинаас хараат буюу архинд донтох өвчтэй хүмүүс байна.

1. Харин пирамидын суурь хэсэгт *архи огт хэрэглэдэггүй* хүмүүсийн бүлэг байрлах бөгөөд үүнд хүүхдүүд орно. Монгол Улсын хуулиар 21 нас хүртэл архи хэрэглэхийг хориглосон байдаг. Мөн энэ бүлэгт:

- Жирэмсэн эмэгтэйчүүд
- Архаг хууч өвчтэй, хүндээр өвчилсөн хүмүүс
- Архинд харшилтай хүмүүс
- Архинаас гарах эмчилгээ хийлгэсэн буюу архи ууж байгаад одоо огт уухаа больсон хүмүүс орно.

2. Тохируулан хэрэглэгчид

Баяр ёслол хамт олноороо цуглах тэмдэглэлт үйл явдлын үед архи

согтууруулах ундааг тодорхой хэмжээгээр тохируулан хэрэглэдэг хүмүүсийг хэлнэ.

Жишээлбэл: 1 удаа уухдаа хундагатай архи 3 – аас илүү уудаггүй.

Эсвэл ийм 300 мл –ийн шар айраг 3- аас илүү уухгүй.

3. Эрсдэлтэй хэрэглэгчид

Хэвийн үед зүгээр, харин архи уусан үед үүсч болох зүйлийг бид эрсдэл гэж нэрлэж байна. Тухайлбал: Жирэмсэн эмэгтэй архи согтууруулах ундаа хэрэглэвэл урагт гажиг үүсч болно. Мөн жирэмсэн эмэгтэйд дутуу төрөх, цус алдах зэрэг олон хүндрэл тохиолдох эрсдэлтэй.

Жолооч хүн машин барьж байхдаа бага хэмжээгээр архи эсвэл айраг ууж болох уу?

Болохгүй. Машин барьж яваа үедээ айраг, согтууруулах төрлийн ундаа хэрэглэж болохгүй. Уусан үедээ жолоо баривал өөрийнхөө амь нас, эд хөрөнгийг аюулд учруулах төдийгүй бусдын эрүүл мэнд, амь нас, эд зүйлсийг аюулд оруулах эрсдэлтэй. Эрүүл үед ийм эрсдэл үүсдэггүй.

4. Асуудалтай хэрэглэгчид

Архийг хэрэглэснээс болж эрүүл мэндийн, нийгэм, хууль зүйн зэрэг олон асуудлуудтай учирдаг. Уг хүн нийгмийн харилцаа болон эрүүл мэндийн хувьд хохирол амссан, гэр бүлээсээ салсан, ажлаасаа халагдсан, эрүүлжүүлэхэд баригдах, ажилгүй мөнгөгүйгээсээ болж хулгай дээрэм хийх, шүүх цагдаад дуудагдах, орон гэргүй, найз нөхөдгүй болох, эрүүл мэндийн талаас олон зовиур шаналгаатай байх зэрэг олон асуудалтай учирдаг. Эдгээр хүмүүс сэтгэл санаагаар унаж яваандаа амиа хорлох оролдлого хийхэд хүрнэ.

Архи уудаг хүн архи уусан үедээ нойр нь шөнө хүрэхгүй, агсам тавьдаг, ууртай догшин, өөртэйгөө ярих, хүмүүсийг буруутгадаг боловч эрүүл үедээ юу



болсныг санахгүй байх нь элбэг тохиолдоно.

Ийм хүмүүс архигүйгээр байж чаддаг ба хараахан хараат байдалд ороогүй байна

5. Хараат хүмүүс буюу архинд донтох өвчтэй хүмүүс

Согтууруулах ундааг удаан хугацаагаар хэтрүүлэн хэрэглэсний улмаас сэтгэл зүйн болон биеийн хараат байдал үүсдэг ба үүнийг архинд донтох өвчин гэдэг.

Ийм хүмүүст нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай. Тэд өөрсдөө архинаас гарах юмсан гэж оролдсон ч сэтгэл зүй, бие махбодь нь архина нэхээд гарч чаддаггүй. Ер нь архинд орсон хүн бол хүнд өвчин туссан гэсэн үг юм. Бид хүнд өвчтэй хүнд тусалдаг шиг ийм хүмүүст мөн зайлшгүй тусламж хэрэгтэй байдаг.

Архинд донтох өвчтэй хүний хамааралд буй хүний төрх байдал:

- Ямар нэг хиймэл албадлагаар өөрийгөө жолоодуулдаг.
- Гэр бүлийн тогтворгүй байдал нь тэр хүнийг амар тайван байлгадаггүй.
- Өөрийгөө тун доогуур үнэлдэг бусдыг ч мөн адил тэгж үнэлнэ.
- Аз жаргалаа бусдад даатгасан байдал
- Бусдын төлөө үргэлж санаа тавьж өөрийгөө зовоодог.
- Архинд донтох өвчтэй болсон хүний гэр бүлийн тогтворгүй харилцаа нь бусадтай эвгүй харьцаа үүсгэхэд нөлөөлдөг.
- Юмыг үгүйсгэх, хэлмэгдүүлэхдээ гарамгай болдог.
- Үе үе уур омогтой болж бяр чадал муу хүмүүст сүр хүчийг үзүүлдэг.
- Юмыг өөрчилж чадаагүйдээ санаа зовж дахин түүнд оролцохоос залхдаг.
- Амьдралдаа алдсан дутуу зүйлээ байнга сэтгэл дотроо эрж хайж байдаг.

Архидалт нь гэр бүлийн дотор байнга айдас, зовиур төрүүлж байдаг ба архинд

донтох өвчтэй хүний эргэн тойронд буй хүмүүст бие сэтгэлийн хүчтэй дарамт нөлөө үзүүлж байдаг. Архидалтыг үл ойшоох ба түүнээс зугтах арга гэр бүлийн гишүүдэд байдаггүй учир тэд архидах зуршлыг тэвчсээр л байдаг. Архинд донтох өвчтэй хүний гэр бүлийнхэн айсан, сандарсан, ичсэн, уурласан, байнгын айдас түгшүүрийн дунд амьдралын бор өдрүүдээ өнгөрөөдөг.

Танд архидан согтуурдаг муу зуршил байгаа юм биш биз.

ӨӨРИЙГӨӨ СОРИХ СОРИЛ

1. Архи ууж байгаагаа багасгах хэрэгтэй гэж бодож байсан уу?
2. Таныг архи ууж байна гэж хэн нэгэн хэлж байсан уу?
3. Би архи хэтрүүлэн хэрэглэж байна гэсэн мэдрэмж төрж байсан уу?
4. Архи уусны маргааш өглөө эвгүйрхсэн дотроо засах гэж архиууж байсан уу?

1 удаа **ТИЙМ** гэж хариулбал согтууруулах ундааны хэрэглээндээ болгоомжтой хандах шаардлагатайг сануулж байна.

2 ба 3 удаа **ТИЙМ** гэж хариулбал хэтрүүлэн хэрэглэгч

Бүгдэд нь **ТИЙМ** гэж хариулбал та Архины хамааралтай хүн болсныг илтгэдэг байна.


Архины албадан эмчилгээнд эмчлүүлж буй өвчтөнүүдээс авсан судалгааны үр дүнгээс:





Оюун ухааны хөгжлийн түвшинг хувиар илэрхийлэхэд: Оюун ухааны өөрчлөлттэй хүмүүс нийт судалгаанд хамрагдагсдын 54,7 хувь, оюун ухааны хязгаарлагдмал түвшинд 33,9 хувь байна.

Зан төлөвийн тодрол




Зан төлөвийн тодролын хувьд:

- Цочромтгой, догдломтгой 26 хүнд буюу 49%
- Солигдомтгой 23 хүнд буюу 43%
- Хэт нягтламтгай 22 хүнд буюу 42%
- Хэт мэдрэмтгий 21 хүнд буюу 40%
- Тэнцвэргүй, хөөрөмтгий 20 хүнд буюу 38%
- Эрч хүчтэй 17 хүнд буюу 32%-д нь дээрх тодролууд илэрсэн.

Темпераментийн онцлог

■ Холерик ■ Меланхолик ■ Сангвиник ■ Флегматик



Холерик, меланхолик темпераментийн онцлогтой хүмүүс нийт хүмүүсийн 85 хувь байна.

Санал, зөвлөмж

Архинд донтох өвчин төлөвшихөд сэтгэл зүйн хүчин зүйл голлох нөлөөтэй болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Архинд донтох өвчин нь хүний эрхэм чанар болох ёс суртахууны мэдрэмжүүд, тухайлбал, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ мэдрэх сэтгэл, нинжин сэтгэл, шудрага ба шудрага бусыг мэдрэх, сайн ба мууг мэдрэх сэтгэл зэрэг илрэл бүхий дотоод сэтгэлийн хөдөлгөөнүүд буурах буюу алдагдахад хүргэдэг шалтгаан юм.

Архаг архичид нь хамт олноос тавьж байгаа нийгэм-ёс суртахууны шаардлагыг биелүүлэх чадваргүй болж байн байн ёс зүйн болон эрхзүйн зөрчил гаргадаг танхай балмад авиртай хүмүүс болон хувирдаг.

Хүний дотоод сэтгэлийн хэмжүүр ба зохицуулагч нь болсон хүний хамгийн нандин чанар болох нинжин сэтгэлд бүр ч илүүтэйгээр хортой нөлөө үзүүлдэг. Хүний нинжин сэтгэл алдагдсанаас ичих, зовох, харамсах, гэмших зэргээр бие хүн өөрөө өөрийгөө шүүх, зэмлэх, шийтгэх чадвараа алдан ёс суртахууны хувьд доголдолтой хүн болон хувирдаг.

Хэрвээ танд архидан согтуурах муу зуршил байдаг бол архины хэрэглээндээ хяналттай хандахыг танд зөвлөж байна.